

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН АВИА ДУУДЛАГЫН СУДАЛГААНЫ ЗАРИМ ДҮНГЭЭС

Б.Төртогтох, магистр, МУБИС

Abstract

Speech requires coordination of the vocal tract, including larynx, glottis, hard and soft palate, jaw, lips and tongue, in addition to the coordination of breathing so that sufficient air is available for speech production (Beverly Otto, 2002). Children's perception of phonemes becomes even more evident during toddler years as the range of words they produce increases. At first, pronunciation of a child's first words is not stable, varying from day to day or even more often. (Beverly Otto, 2002). Preschool children's receptive awareness and production of language-related sounds (phonemes) is fairly well developed (Gonzales-Mina, J. 2011).

The first orientation of early childhood development can be seen from their language development and one of main criteria of language development is their ability of phone pronunciation. Today, there is no any study contacted phone pronunciation of early childhood and this kind of study should be investigated every year in Mongolia.

In this paper we introduce some results of the phonological study of early childhood, conducted in March and April, 2015. By this research we have tried to conduct some features regarding to vowel and consonant sound pronunciation pronouncing them not only alone but also in words. Therefore we have developed an overview chart of phoneme production of early childhood.

Түлхүүр үг

Бага насны хүүхэд, хэл ярианы хөгжил, авиа дуудлага, хүүхдийн хөгжил

Удиртгал

Хүний оюун ухааны хөгжлийн нэг чухал илрэл нь тэдний хэл ярианы чадвар байдаг. Бага насны хүүхдийн хувьд хэл яриа хөгжих суурь нь авиа дуудлага юм. Ийм учраас сургуулийн өмнөх насны хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг үнэлэхэд авиа дуудлага чухал шалгуур болох учиртай. Иймд бага насны хүүхдийн авиа дуудлагын судалгаа хувь хүүхдийн хувьд төдийгүй үндэсний хэмжээнд байнга хийгдэж байх ёстой судалгааны нэг байх үндэстэй билээ. Гэтэл ийм төрлийн судалгаа манайд тогтмол хийгддэггүй төдийгүй тодорхой тоймтой судалгаа өнөө хэр байхгүй байгаа билээ.

Энэхүү судалгаагаар бид Монголын бага насны хүүхдийн авиа дуудлагын өнөөдрийн төлөв байдлыг тодруулах зорилго тавьсан юм.

Энэхүү судалгаа нь 2 хэсгээс бүрдсэн.

Үүнд:

Авиаг дангаар нь дуудаж буй байдал

Авиаг үгэнд оруулан дуудаж буй байдал

1. Хүүхдийн дан авиа дуудлагын байдлыг судлахдаа урьдчилан сонгон авсан авиануудыг хүүхэд бүрээр дагуулан хэлүүлж авиа бүрийн дуудагдаж байгаа байдлыг галиглан бүртгэж авах замаар мэдээллийг цуглуулсан юм. Үүнд, монгол хэлний үндсэн 7 эгшиг, я, е, ё, ю гэсэн туслах 4 эгшиг, “щ” гийгүүлэгчээс бусад авиануудыг сонгож авлаа.

2. Хоёр дахь хэсэг нь зөвхөн гийгүүлэгч авиануудыг

дуудаж байгаа байдлыг үнэлэхэд чиглэсэн. Хүүхдүүдээр тусгайлан сонгож авсан үгнүүдийг дагуулан хэлүүлж, тухайн гийгүүлэгч авиа ямар байдлаар дуудагдаж байгааг галиглан бүртгэн авсан юм. Үгийг сонгохдоо дараах зарчмыг баримталлаа.

Үүнд:

Нэгээс хоёр үетэй

Нэг үгэнд гурваас дээшгүй гийгүүлэгч авиа орсон

Үгс нь хүүхдийн идэвхтэй үгийн санд багтаж байх

Судалгааны мэдээллийг боловсруулахдаа дараах зарчмыг баримталсан болно.

Үүнд:

Дөрвөн насны шатлал: 2 нас - (2 нас1 хоног 2 нас 11 сар 29 хоног), 3 нас - (3 нас 1 хоног-3 нас 11 сар 29 хоног), 4 нас - (4 нас 1 хоног-4 нас 11 сар 29 хоног), 5 нас - (5 нас 1 хоног - 5 нас 11 сар 29 хоног)

Судалгааны хамрах хүрээ


Судалгаанд 2 хот, 6 аймгийн 1083 хүүхэд хамрагдсан ба тэдгээрээс 2 настай 200 хүүхэд буюу энэ нь судалгааны хамрагдагсдын 18.5%, 3 настай 258 буюу 23.8%, 4 настай 315 буюу 29.1%, 5 настай 310 буюу 28.6%-ийг эзэлж байна. Судалгаанд хамрагдсан хүүхдийн тоог аймаг тус бүрээр 1-р зурагт харууллаа.

Хязгаарлагдмал байдал

Бага насны хүүхдийн авиа дуудлагын судалгааг хийхийн тулд Монгол улсын нутаг дэвсгэрт оршин суугаа бага насны хүүхдүүдийг тэнцвэртэй хамруулахыг хичээсэн боловч төвийн бүсийн орон нутгийг хамруулсан нь алс хязгаарлагдмал орон нутгийн ард иргэдэд нутгийн аялга, хэл ярианы онцлог шингэсэн байх тул тэнд амьдран суух бага насны хүүхдийн авиа дуудлагын онцлогийг судалж үзэхийг хойш тавьсан болно.

График 1

Судалгаанд хамрагдсан хүүхдийн тоо /орон нутгаар/



Судалгааны баг: Судалгаанд МУБИС-ийн Багшийн сургуулийн Сургуулийн өмнөх боловсролын салбар сургуулийн өдрийн 3-р курсийн оюутнууд оролцсон болно.

Үндсэн хэсэг

Эгшиг авиа дуудлагын байдал

Судалгаанд хамрагдагчдын үндсэн болоод туслах эгшиг авиануудыг дуудсан байдлыг авч үзвэл:

а. Үндсэн долоон эгшиг авианы хувьд:

Хүснэгт 1

Үндсэн эгшиг авиа дуудаж буй байдал

Үндсэн эгшиг	2 нас		3 нас		4 нас		5 нас		Дундаж хувь
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	
а э и о у	200	100	258	100	315	100	310	100	100
ө	200	100	258	100	312	99.0	307	99.0	99.5
ү	200	100	258	100	315	100	306	98.7	99.6

Эндээс харахад “ө”, “ү”-ээс бусад эгшиг авиаг бүх хүүхдүүд зөв дуудаж чадаж байсан ба харин “ө”, “ү” эгшигийг цэцэрлэгийн ахлах насны цөөн тооны хүүхэд “өү” хэмээн хоёр авианы нийлэмжээр дуудаж байгаа (0.4% орчим) нь ажиглагдсан. Гэхдээ энэ нь тухайн судалгаанд орсон цөөн хүүхдийн хувьд ажиглагдсан тохиолдлын үзэгдэл гэж үзэж болох юм.

б. Туслах эгшиг авианы хувьд:

Хүснэгт 2

Туслах эгшиг авиа дуудаж буй байдал

Туслах эгшиг	2 нас		3 нас		4 нас		5 нас		Дундаж хувь
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	
я	200	100	255	98.8	305	96.8	310	100	98.9
ё	200	100	245	95.0	302	95.9	306	98.7	97.4
е	198	99	243	94.2	306	97.1	300	96.8	96.8
ю	188	94	223	86.4	306	97.1	290	93.5	92.7


Туслах эгшиг авианы хувьд үндсэн эгшиг авиануудын дуудлагатай харьцуулахад буруу дуудлага илүү байгаа нь бүх авиа дээр харагдаж байна. Тухайлбал, “ю” авиаг судалгаанд хамрагдагчдын 7.3% нь “у”, “ү” авиагаар, “е” авиаг “э” авиагаар (3.2%), “ё” авиаг “о”, “но”

авиагаар (1.9%-2.2%) дуудаж байлаа. Мөн 3, 4, 5 насанд авиаг буруу дуудах нь хоёр наснаас илүү илэрч байгаа нь хүүхдийн авиа дуудлага болон ер нь тэдний ярианы хөгжилд орчин тодорхой хэмжээгээр нөлөөлдөгтэй холбоотойн илрэл юм. Гийгүүлэгч авиа дуудлагын байдал Гийгүүлэгч авианы дуудлагыг нас насаар нь авч үзвэл:

а. 2 настны хувьд:

График 2

2 настнуудын гийгүүлэгч авиа дуудаж буй байдал



Дээрх зургаас харахад: 2 настнуудын талаас дээш хувь нь (52%) бүх гийгүүлэгч авиаг зөв дууддаг болсон байгаа нь ажиглагдлаа.


Судалгаанд оролцсон 2-3 настнуудын тал хувь нь буюу 52% нь “р” авиаг буруу дуудаж байгаа нь тэдний хувьд дуудахад хамгийн хүнд авиа нь болох нь харагдаж байна. Харин 31.5% нь “р” авиаг “л”, 10.5% нь “эе”, 2% нь “д” авиагаар сольж хэлж байсан ба 4% нь хариу хэлээгүй буюу хариулаагүй байна.

Харин судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 80-85% “ш”, “з”, “ч”, “ж”, “ц” авиаг, 70-80% нь “с”, “н” авиаг, 60-70% нь “ф”, “т” авиаг буруу дуудаж байгаа байдал харагдаж байна. Эдгээр авианууд 3-4, 4-5 настнуудад хувь нь дээшилсэн боловч буруу дуудагдах байдал үргэлжилсээр байдаг нь харагдах болно.

б. 3 настны хувьд:

График 3

3 настнуудын гийгүүлэгч авиа дуудаж буй байдал / зөв дуудлагын хувиар/



Дээрх зургаас ажиглахад: 3 настнуудын 64.9-с дээш хувь нь гийгүүлэгч авиаг зөв дуудаж чаддаг

болсон байгаа нь харагдаж байна.

Судалгаанд оролцсон энэ насны хүүхдүүдийн хувьд авиа зөв дуудах хувь нь дээшилсэн ба 2-3 настнуудад гарч байсан онцлогууд давтагдаж байна. Тэдний 64.9% нь “р” авиаг хэлэхэд бэрхшээлтэй байгаа нь өмнөх настнуудынхаас хувь хэмжээ нь нэмэгдсэн ч бага насны хүүхдийн хувьд хэлэхэд хүндрэлтэй авиа хэвээр байсаар байна. Учир нь 2-3 настнуудын 10-15% нь 3-4 насандаа “р” авиа дуудлагаа засаж чадсан байдаг байна.

Өмнөх насанд 85%-с бага хувьтай гарсан 11 авиа байсан бол хөгжлийн дараагийн үе болох 3-4 насанд 8 болж байгаа нь:


а. Бага насны хүүхдийн хөгжил хэчнээн хурдацтай эрчимтэй явагдаж байдгийг баталж байна.

б. “ф”, “т”, “з” авиа хасагдсан буюу зөв дуудагдах болсон нь бүгд хэлний үзүүрт хэлэгддэг гийгүүлэгчүүд байгаа нь хүүхдийн өгүүлэх эрхтний хөгжлийн зүй тогтлыг харуулж байна.

в. 4 настнуудын хувьд:

График 4

4 настнуудын гийгүүлэгч авиа дуудаж буй байдал / зөв дуудлагын хувиар/



Зургаас харахад: 4 настнуудын 81.9-с дээш хувь нь гийгүүлэгч авиаг зөв дуудаж чаддаг болсон байгаа нь тэдний авиа дуудах чадвар сайжирч байгааг илтгэж байна.


Бага насны хүүхдүүдийн хэлэхэд хамгийн хэцүү “р” авиа энэ насны хүүхдүүдийн хувьд ч үргэлжилж байгааг судалгаанд оролцсон хүүхдүүдийн 81.9% зөв дуудаж байгаагаас харж болно. Энэ нь бас тэдний өгүүлэхүйн эрхтний хөгжил, хэл ярианы хөгжлийн хурдцыг харуулж байна.

Дээрх графикаас харахад энэ насны хүүхдүүдийн 80% - д нь авиа зөв дуудлага төлөвшсөн байдаг ба энэ тэдний ярих чадвар, өөрийгөө илэрхийлэх, өөртөө итгэх итгэлд зэрэгт эергээр нөлөөлөх учир тэдний ярих, бусадтай харилцах чадварт энэ насанд ахиц гардаг нь мөн дамжиггүй юм. Энэ судлах л ёстой судалгааны асуудал юм.

г. 5 настнуудын хувьд:

График 5

5 настнуудын гийгүүлэгч авиа дуудаж буй байдал /зөв дуудлагын хувиар/



Судалгаанд хамрагдсан 5 настнуудын 88.7-с дээш хувь нь гийгүүлэгч авиаг зөв дууддаг болсон байдаг нь дээрх графикаас харагдаж байна. Мөн сонирхол татсан зарим нэг үзүүлэлтүүд гарсныг дурдвал:

Өмнөх настнуудад хамгийн бэрхшээлтэй байсан “р” авиаг зөв дуудах хүүхдийн тоо энэ насанд өссөн дүнтэй боловч урьд нь харьцангуй зөв дуудагдаж байсан зарим авиа энэ насанд буруу дуудагдах болсон. Жишээ нь: “ц”, “с”, “з” авиануудыг буруу дууддаг хүүхдүүдийн хувь тийм өндөр биш боловч энэ насанд буруу дуудагддаг авиануудын жагсаалтыг тэргүүлж байна.


Энэ мэт авиануудын байр солигдсон ч сургуульд ороход 6 настнуудын 94.7% нь зөв дуудлагатай болсон байдаг таатай нэгэн үзүүлэлт харагдаж байна.

Гийгүүлэгч авианы дуудлагыг гийгүүлэгч тус бүрээр авч үзвэл:

а. “р” гийгүүлэгчийн хувьд:

Зураг 6

“р” авиа дуудагдаж буй байдал /нас насаараа/



Эндээс харахад “р” авиа дуудлага нас ахих тусам сайжирч байгаа ч сургуульд ороход судалгаанд хамрагдагчдын 88.7 хувь нь л зөв дууддаг болсон байдаг байна.

Судалгааны үр дүн:

Судалгааны дээрх мэдээллийг нэгтгэн бид дараах хүснэгтийг гаргаж болохоор байна.

Хүснэгт 3

Бага насны хүүхдийн авиа дуудаж буй ерөнхий төлөв

Хүүхдийн нас	100% - 90%	90% - 80%	80% - 70%	70% - 60%	60% - 50%
2-3	“б”, “х”, “м”, “н”, “л”, “г”, “д”	“к”, “ш”, “з”, “в”, “ч”, “ж”, “ц”, “с”	“с”, “п”	“т”, “ф”	“р”
3-4	“б”, “х”, “м”, “н”, “л”, “г”, “д”	“к”, “т”, “з”, “ф”, “ч”, “ш”, “в”, “п”, “ж”	“ц”, “с”	“р”	
4-5	“х”, “м”, “г”, “л”, “б”, “н”, “с”, “к”, “д”, “п”, “ц”, “т”, “в”, “с”	“ж”, “ш”, “ч”			
5-6	“м”, “г”, “х”, “н”, “б”, “д”, “л”, “в”, “п”, “т”, “ж”, “ч”, “ш”, “р”, “ц”, “с”	“з”			

Энэ хүснэгтээс харахад бага насны хүүхдийн 50 хувь нь бүх авиаг цэвэр дуудаж чаддаг болсон байдаг ба сургуульд орох нас буюу 6 нас гэхэд нийт хүүхдийн 90-100 хувь нь бүх авиаг дангаар болон үгэнд оруулан дуудахдаа цэвэр дууддаг болсон байдаг нь харагдаж байна. Мөн энэ хүснэгтээс монгол хүүхдийн ихэвчлэн алдаж дууддаг авиаг харж болох ба энэ онцлогийг сургуулийн өмнөх боловсролын багш нар өөрсдийн үйл ажиллагаандаа анхааран ажиллах болох юм.

Дүгнэлт

Бага насны хүүхдүүд эгшиг авиа, туслах эгшиг авиануудыг дангаар дуудахад бэрхшээлгүй, буруу дуудлага илэрдэггүй бол эдгээр эгшгүүд орсон үгсийг хэлэхэд тэдний өөр эгшгээр, үеэр орлуулан дуудах байдал ажиглагдаж байлаа.

Бага насны хүүхдүүдийн хувьд дуудахад хамгийн хэцүү авиа нь “р” авиа болох нь дээрх судалгааны дүнгээс харагдаж байна. Мөн дуудахад алдаатай хэлэгддэг “л” авианы хувьд дангаар нь хэлэхэд хүүхдүүд төдийлөн алдаатай дууддаггүй бол үгэн дунд оруулан хэлэхдээ ихээхэн алддаг болох нь судалгааны материалаас ажиглагдлаа. Гэхдээ “л” авиа ямар авиатай хамт хэлэгдэхдээ буруу дуудагдаж байгааг илүү нарийвчлан судлах ёстой юм.

Сургуулийн өмнөх насанд дуудахад хэцүү авиануудыг гаргаж болохоор байна. Үүнд: “р”, “с”, “ц”, “ш”, “з”, “ж”, “ч” зэрэг гийгүүлэгчүүд нь дангаар болон үгэнд оруулан дуудахад бэрхшээлтэй байдаг байна.

Буруу дуудагдаж буй авиануудыг ерөнхийд нь ажиглахад хэлний дундуурх, хэлний хойгуурх, хамжих, шүргэх, чичрэх авианууд байгаа нь бага насны хүүхдийн хэл ярианы хөгжилд өгүүлэхүйн эрхтний дасгал ихээхэн чухал нөлөөтэйг харуулж байна. Уруулын болон хэлний үзүүрт хэлэгддэг ихэнх авианууд дангаар болон үгэнд дунд зөвөөр дуудагдаж байгаа нь эдгээр авиануудыг хэлэхэд өгүүлэхүйн эрхтний хөдөлгөөн төдийлөн оролцдоггүйгэй холбоотой юм.

Дээрх дүгнэлтээс харахад хүүхдийн өгүүлэхүйн эрхтний хөгжил урдаас хойш чиглэсэн байдлаар хөгждөг нь харагдаж байна. Иймд бид өгүүлэхүйн эрхтний дасгалыг багаас нь өдөр тутмын үйл ажиллагаандаа оруулан хөгжүүлж хэвшвэл бага насны хүүхдийн авиа дуудлага эрт сайжрах нь дамжиггүй юм.

Талархал: Энэхүү судалгааг авахад тусалсан 2014-2015 оны хичээлийн жилийн өдрийн 3-р курсийн бүх оюутнууддаа талархлаа илэрхийлье.

Ашигласан материал

- John W. Santrock. (2004). Child development. New York, NY: McGraw-Hill Companies.
- Beverly Otto. (2002). Language Development in Early Childhood. Upper Saddle River, NJ: Pearson Education Inc.
- Gonzalez-Mina, J. (2011). Foundation of Early Childhood Education: Teaching Children in Diverse Setting. (5th ed.). New York: McGraw-Hill.
- <http://www.meds.gov.mn/> Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны төсвийн төсөл.
- <http://www.meds.gov.mn/data/1409/Tusul2015.pdf>